

БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ХӨВСГӨЛ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/90/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 70383793 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ Утас: 99900662 Цахим хаяг: bat-erdenee@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Утас: Л.Отгонбаяр Цахим хаяг: imfo@bizkon.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХӨА	Хөвсгөл аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsugul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/22
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.НЯМХАНД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>126,498,378.78</u>	<u>124,993,652.88</u>
33	АВЛАГА	00.00	181,280.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	181,280.00
35	БАРАА МАТЕРИАЛ	126,498,378.78	124,812,372.88
351	Түүхий эд материал	2,953,800.00	1,465,400.00
35130	Эм боох материал	2,953,800.00	1,465,400.00
354	Хангамжийн материал	122,729,578.78	122,623,372.88
35410	Бичиг хэргийн материал	2,963,500.00	1,376,000.00
35420	Аж ахуйн материал	82,390,462.28	68,414,082.28
35440	Түлш, шатах тослох материал	3,470,000.00	1,579,900.00
35460	Хүнсний материал	5,462,549.40	2,911,323.50
35470	Бусад хангамжийн материал	28,443,067.10	48,342,067.10
35600	Мал амьтад	815,000.00	723,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>680,640,594.99</u>	<u>688,284,904.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	680,640,594.99	688,284,904.67
392	Биет хөрөнгө	665,082,594.99	672,451,904.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	683,568,891.02	707,811,543.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,140,507.96	-69,720,358.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,530,501.00	37,451,577.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,314,601.32	-10,792,647.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,718,292.00	18,355,232.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,279,979.75	-10,653,442.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	162,903.00	162,903.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-162,903.00	-162,903.00
393	Биет бус хөрөнгө	15,558,000.00	15,833,000.00
39301	Программ хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,558,000.00	15,558,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>807,138,973.77</u>	<u>813,278,557.55</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>807,138,973.77</u>	<u>813,278,557.55</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	807,138,973.77	813,278,557.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	67,416,088.00	67,416,088.00
51101	Өмч: - төрийн	67,416,088.00	67,416,088.00
512	Хуримтлагдсан үр дүн	505,407,541.46	513,018,473.24
51210	Өмнөх үеийн үр дүн	505,407,541.46	506,878,889.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,139,583.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,315,344.31	232,843,996.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>807,138,973.77</u>	<u>813,278,557.55</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	488,656,605.00	470,854,927.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,919,405.00	63,165,327.08
120	Нийтлэг татварын бус орлого	8,919,405.00	63,165,327.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,919,405.00	63,165,327.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,200.00	74,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,816,205.00	63,090,727.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,846,000.00	56,802,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,891,200.00	350,886,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,846,000.00	56,541,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,846,000.00	56,541,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	459,759,478.67	464,715,343.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	459,759,478.67	464,715,343.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,541,042.67	462,298,809.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,340,911.00	289,729,603.90
210101	Үндсэн цалин	284,340,911.00	212,869,055.90
210102	Нэмэгдэл	00.00	62,504,615.00
210104	Урамшуулал	00.00	14,355,933.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,343,578.00	37,618,712.10
210201	Тэтгэврийн даатгал	25,194,682.00	26,245,284.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,845,493.00	2,901,994.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,276,391.00	2,321,595.50
210204	Ажилгүйдлийн даатгал	539,323.00	550,795.55
210205	Эрүүл мэндийн даатгал	5,487,689.00	5,599,041.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,947,676.00	48,883,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,857,876.00	1,000,000.00
210302	Түлш, халаалт	46,089,800.00	47,883,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,335,070.00	42,648,830.00
210401	Бичиг хэрэг	5,033,500.00	5,689,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	1,845,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,196,000.00	999,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,720,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,285,570.00	34,114,230.00
2105	Нормативт зардал	22,483,434.10	11,097,995.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	904,500.00	2,345,600.00
210502	Хоол, хүнс	21,578,934.10	8,752,395.90

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,800.00	921,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,800.00	381,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,013,573.57	31,397,967.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	566,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	84,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,929,573.57	30,831,267.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,218,436.00	2,416,534.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	349,200.00	191,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	349,200.00	191,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,869,236.00	2,225,534.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,869,236.00	2,225,534.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	28,897,126.33	6,139,583.78
5	НИЙТ ҮР ДҮН	28,897,126.33	6,139,583.78

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,416,088.00	234,315,344.31	476,510,415.13	778,241,847.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,416,088.00	234,315,344.31	476,510,415.13	778,241,847.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,897,126.33	28,897,126.33
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,416,088.00	234,315,344.31	505,407,541.46	807,138,973.77
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,416,088.00	234,315,344.31	505,407,541.46	807,138,973.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,471,348.00	1,471,348.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,416,088.00	234,315,344.31	506,878,889.46	808,610,321.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт	00.00	-1,471,348.00	00.00	-1,471,348.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,139,583.78	6,139,583.78

D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,416,088.00	232,843,996.31	513,018,473.24	813,278,557.55
-----	---------------------------------------	---------------	----------------	----------------	----------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	479,737,200.00	407,689,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,737,200.00	407,689,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,891,200.00	350,886,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,846,000.00	56,541,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,846,000.00	56,541,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,737,200.00	407,689,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,737,200.00	407,689,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,817,964.00	405,464,066.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,340,911.00	289,729,611.00
210101	Үндсэн цалин	247,944,511.00	208,651,162.00
210102	Нэмэгдэл	18,247,400.00	61,317,740.00
210104	Урамшуулал	18,149,000.00	19,760,709.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,343,578.00	37,799,985.00
210201	Тэтгэврийн даатгал	25,952,878.00	27,106,185.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,597,800.00	2,673,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,078,000.00	2,138,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,900.00	534,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,195,000.00	5,347,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,483,800.00	47,813,700.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	1,000,000.00
210302	Түлш, халаалт	47,983,800.00	46,813,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,239,400.00	9,292,300.00
210401	Бичиг хэрэг	375,000.00	286,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,920,000.00	1,025,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,196,000.00	999,300.00
210404	Ном, хэвлэл	295,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360,000.00	261,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,092,700.00	6,719,400.00
2105	Нормативт зардал	27,516,275.00	6,796,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,218,300.00	595,400.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	14,395,725.00	6,201,170.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,902,250.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,012,200.00	8,727,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,150,000.00	00.00
210604	Урсгал засвар	19,862,200.00	8,727,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,800.00	921,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,800.00	381,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,805,000.00	4,382,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	566,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,805,000.00	3,816,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,919,236.00	2,225,534.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,869,236.00	2,225,534.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,869,236.00	2,225,534.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,000,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,000,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,000,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,000,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-7,000,000.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	407,427,800.00	405,202,266.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,427,800.00	405,202,266.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,427,800.00	405,202,266.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,348,400.00	289,729,611.00
210101	Үндсэн цалин	213,692,800.00	208,651,162.00
210102	Нэмэгдэл	58,506,600.00	61,317,740.00
210104	Урамшуулал	18,149,000.00	19,760,709.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,197,000.00	37,799,985.00
210201	Тэтгэврийн даатгал	27,583,100.00	27,106,185.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,903,400.00	2,673,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,322,800.00	2,138,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	580,700.00	534,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,807,000.00	5,347,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,813,700.00	47,813,700.00

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,000,000.00
210302	Түлш, халаалт	46,813,700.00	46,813,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,030,500.00	9,030,500.00
210401	Бичиг хэрэг	286,300.00	286,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,025,500.00	1,025,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	999,300.00	999,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,719,400.00	6,719,400.00
2105	Нормативт зардал	6,796,700.00	6,796,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	595,400.00	595,400.00
210502	Хоол, хүнс	6,201,300.00	6,201,170.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,727,300.00	8,727,300.00
210604	Урсгал засвар	8,727,300.00	8,727,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	981,900.00	921,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	381,900.00	381,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	453,230.00	438,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	715,600.00	566,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,816,700.00	3,816,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	407,427,800.00	405,202,266.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	350,886,800.00	348,661,266.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	350,886,800.00	348,661,266.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,541,000.00	56,541,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	56,541,000.00	56,541,000.00
	Ажиллагсдын тоо	27	27
	Удирдах ажилтан	1	1
	Гүйцэтгэх ажилтан	14	14
	Үйлчлэх ажилтан	12	12

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	261,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	261,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	261,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарын ахлах аудитор Л.Отгонбаяр, аудитор Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэг нь Бага насны хүүхдийн сурч хөгжихөд ээлтэй ая тухтай орчин бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, багш ажилчдын ажлын байрыг ажиллах таатай нөхцөлөөр бүрдүүлэх чиг үүрэг бүхий орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх, “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “9.5” гэснийг “8.5” гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.7” гэснийг “11.7” гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “12.5” гэснийг “11.5” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “12.5 хувиас” гэснийг “11.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 459.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.1 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага 0.1 сая төгрөгөөр нэмэгдэж, бараа материалын данс 1.6 сая төгрөгөөр буурч үндсэн хөрөнгийн данс 7.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.1	0.1
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	126.4	124.8	-1.6
Үндсэн хөрөнгө	680.6	688.2	7.6
Нийт хөрөнгө	807.1	813.2	6.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	807.1	813.2	6.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	807.1	813.2	6.1

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байхгүй, 0.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124.8 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 124.8 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан нь ковид цар тахлаас үүдэн хичээл цэцэрлэгийн үйл ажиллагаа эхний хагас жилд ороогүй

хязгаарлагдсан учраас хүнсний материалын худалдан авалт буурсан, жилийн эцэст татан авалт болон нөөц бага бэлдэж өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан учир бараа материал данс буурсан байна. Бараа материалын дансны эхний үлдэгдэлд 126.4 сая төгрөг тайлант онд худалдаж авсан 29.2 сая төгрөг, хандиваар 24.7 сая төгрөг, зарцуулсан нь 55.7 сая төгрөг, нөөцөд үлдсэн 124.8 сая төгрөгийн бараа материал үлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 688.3 сая төгрөг болж 7.6 сая төгрөгөөр өссөн нь ажилчдын барьсан 24.9 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбай хашаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.7 сая төгрөгийн компьютер принтер тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн зэрэг нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данснаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 26.7 сая төгрөгийн хөрөнгө /0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлсэн/, 6.4 сая төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 813.2 сая төгрөг байна.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө материал 54.2 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 0.3 сая төгрөгөөр тус тус өссөн, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 12.3 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 62.2 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 1.5 төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулгад бичилт хийсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 606.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 606.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 199.4 сая төгрөгөөр бууруулж 407.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсөвт 2 удаа зохицуулалт хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 350.9 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 56.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 407.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 405.2 сая төгрөгийг зарцуулж, 2.2 сая төгрөгөөр дутуу санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 405.2 сая төгрөг буюу 99.5 хувьтай байна.

Дараах зардлуудыг дутуу санхүүжүүлсэн байна. Үүнд: цалин хөлсний зардал 0.6 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 1.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардал 0.06 сая төгрөг, бараа үйлчилгээний зардал 0.2 сая төгрөг, хоол хүнсний зардал 0.0001 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 0.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, хангамж, бараа материалын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

Ковид 19 цар тахалтай холбоотойгоор тус төв нь цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажилласан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар анхны батлагдсан төсөвт тодотгол хийж 37.6 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/608 захирамжаар 4.8 сая төгрөгөөр нийт 42.4 сая төгрөгөөр хасах тодотгол хийсэн байна.

Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж зарим нэгэн зардалд хэмнэлт гаргасан, ковид-19 цар тахалтай холбоотойгоор хичээл, сургалтын үйл ажиллагаа хязгаарласан явдал байна. Үүнд: Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.0 сая төгрөг, тээвэр шатахууны зардал 0.9 сая төгрөг ном хэвлэлийн зардлаас 0.3 сая төгрөг, хоол, хүнсний зардал 65.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж батлагдаагүй дутуу санхүүжүүлсэн цалин хөлс болон нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 722.5 сая төгрөгийн /давхардсан тоогоор/ 151 мэдээллээс 722.5 сая төгрөгийн 146 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Хуулийн (6.4.5 цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн дүн) 82.9 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно. Тайлант 129.1 сая төгрөгийн үнэ бүхий 18 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд харьцуулалтын аргаар 14, шууд худалдан авах аргаар 4 арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, санал гомдол байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн буруу илэрхийлэл, алдаа зөрчил илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.